

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2016 оны 2 сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн
нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ыг
шинэчлэн батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 31.2, 32.2, 65.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 18.2, 19.2, 34.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. Даатгалын компанид мөрдөх “Дансны жагсаалт”-ыг нэгдүгээр, “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ыг батлах тухай 2009 оны 275 дугаар тогтоол, “Даатгалын компанид мөрдөх дансны үлгэрчилсэн заавар”-ыг батлах тухай 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 373 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

3. Хавсралтаар шинэчлэн батлагдсан журам, дансны жагсаалтыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

Санхүүгийн зохицуулах хорооны
2016 оны ... дүгээр сарын ... өдрийн
... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**ДААТГАГЧ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН
САНХҮҮГИЙН НЭМЭЛТ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА,
МАЯГТЫГ ТОГТООХ ЖУРАМ**

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 31.2, 32.2 дахь заалт, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 18.2, 19.2 дахь заалтын дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтооход оршино.

1.2. Энэ журмын дагуу дараах даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч этгээд (цаашид “даатгалын байгууллага” гэх) нь санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайлангийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд цаасаар болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны цахим бүртгэл (FINA программ)-д илгээх, 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн хамт дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор Хорооны цахим бүртгэл (FINA программ)-д илгээнэ:

- 1.2.1. Ердийн даатгалын компани;
- 1.2.2. Урт хугацааны даатгалын компани;
- 1.2.3. Давхар даатгалын компани;
- 1.2.4. Даатгалын зуучлагч компани;
- 1.2.5. Даатгалын хохирол үнэлэгч компани.

1.3. Даатгалын байгууллага нь энэ журмын хавсралтаар батлагдсан мэдээллийг энэ журмын 1.2-т заасан хугацаанд Хороонд бичгээр ирүүлэх болон Хорооны цахим бүртгэл (FINA программ)-д үнэн зөв илгээсэн нөхцөлд санхүүгийн тайланг бүрэн ирүүлсэнд тооцно.

1.4. Даатгагч, даатгалын байгууллага нь салбар, төлөөлөгчийн газрын санхүүгийн нэмэлт тайланг нэгтгэж, нэгдсэн тайланг Хороонд ирүүлнэ.

1.5. Даатгалын байгууллага улирал тутам ирүүлэх санхүүгийн тайлангийн хамт банкин дахь харилцах, хадгаламжийн хуулгыг ирүүлэх, эсвэл банкин дахь хуулгыг цахим хэлбэрээр хянах эрхийг холбогдох Хорооны хянан шалгагчид олгох;

1.6. Ердийн даатгалын компани нь Хорооноос баталсан дансны жагсаалтын дагуу мэдээллийг улирал бүр цахим бүртгэл (FINA программ)-д оруулна.

ХОЁР. Санхүүгийн нэмэлт тайлан гаргах, ирүүлэх

2.1. Ердийн даатгалын компани нь Даатгалын тухай хуулийн 29.3-т заасны дагуу Хорооноос баталсан “Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга”-д тусгасан санхүүгийн тайлан, тодруулгаас гадна дараах мэдээллийг энэ журмын 1.2-т заасан хугацаанд гаргаж, Хороонд ирүүлнэ:

- 2.1.1. Дүрмийн сангийн хөрөнгийн байршлын талаарх мэдээллийг энэ журмын 1 дүгээр хавсралтаар;
- 2.1.2. Хөрөнгийн эрсдэлийн талаарх мэдээллийг 2 дугаар хавсралтаар;
- 2.1.3. Орлого, зарлагын талаарх мэдээллийг энэ журмын 3 дугаар хавсралтаар;
- 2.1.4. Даатгуулагчийн тухай мэдээллийг энэ журмын 4 дүгээр хавсралтаар;
- 2.1.5. Даатгасан даатгалын зүйлийн тухай мэдээллийг энэ журмын 5 дугаар хавсралтаар;
- 2.1.6. Нөөц сангийн тухай мэдээллийг энэ журмын 6 дугаар хавсралтаар;
- 2.1.7. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн тухай мэдээллийг энэ журмын 7 дугаар хавсралтаар;
- 2.1.8. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн тухай мэдээллийг энэ журмын 8 дугаар хавсралтаар;
- 2.1.9. Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн тухай мэдээллийг энэ журмын 9 дүгээр хавсралтаар;
- 2.1.10. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн талаарх мэдээллийг энэ журмын 10 дугаар хавсралтаар;
- 2.1.11. Давхар даатгалын талаарх мэдээллийг энэ журмын 11 дүгээр хавсралтаар;
- 2.1.12. Даатгалын компанийн салбарын ерөнхий мэдээллийг энэ журмын 12 дугаар хавсралтаар;
- 2.1.13. Даатгалын компанийн нэгдлийн талаарх мэдээллийг 13 дугаар хавсралтаар;
- 2.1.14. Холбоотой этгээдүүдтэй хийсэн гүйлгээний талаарх мэдээллийг 14 дүгээр хавсралтаар;
- 2.1.15. Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн талаарх мэдээллийг 15 дугаар хавсралтаар;
- 2.1.16. Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг 16 дугаар хавсралтаар.

2.2. Урт хугацааны даатгалын компани нь Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн А маягт”-аар жилийн санхүүгийн тайланг_ “Санхүүгийн тайлангийн Б маягт”-аар улирал тутмын санхүүгийн тайланг ирүүлэхээс гадна дараах мэдээллийг энэ журмын 1.2-т заасан хугацаанд гаргаж Хороонд ирүүлнэ:

- 2.2.1. Орлого, зарлагын талаарх мэдээллийг энэ журмын 28 дугаар хавсралтаар;
- 2.2.2. Дүрмийн сангийн хөрөнгийн байршлын талаарх мэдээллийг энэ журмын 1 дүгээр хавсралтаар;
- 2.2.3. Хөрөнгийн эрсдэлийн талаарх мэдээллийг 2 дугаар хавсралтаар;
- 2.2.4. Даатгалын үнэлгээ, даатгалын хураамж, даатгуулагчийн тухай мэдээллийг энэ журмын 29 дүгээр хавсралтаар;
- 2.2.5. Нийт хураамжийн орлогын талаарх мэдээллийг энэ журмын 30 дугаар хавсралтаар;
- 2.2.6. Нөхөн төлбөр, нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тухай мэдээллийг энэ журмын 31 дүгээр хавсралтаар;
- 2.2.7. Нэхэмжлэлийн талаарх мэдээллийг энэ журмын 32 дугаар хавсралтаар;
- 2.2.8. Нөөц сангийн тухай мэдээллийг энэ журмын 33 дугаар хавсралтаар;
- 2.2.9. Хувь оролцоотой гэрээний нөөц сангийн тухай мэдээллийг энэ журмын 34 дүгээр хавсралтаар;

- 2.2.10. Хувь оролцоогүй гэрээний нөөц сангийн тухай мэдээллийг энэ журмын 35 дугаар хавсралтаар;
- 2.2.11. Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангийн тухай мэдээллийг энэ журмын 36 дугаар хавсралтаар;
- 2.2.12. Даатгалын компанийн салбарын ерөнхий мэдээллийг энэ журмын 12 дугаар хавсралтаар;
- 2.2.13. Даатгалын компанийн нэгдлийн талаарх мэдээллийг 13 дугаар хавсралтаар;
- 2.2.14. Холбоотой этгээдүүдтэй хийсэн гүйлгээний талаарх мэдээллийг 14 дүгээр хавсралтаар;
- 2.2.15. Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн талаарх мэдээллийг 15 дугаар хавсралтаар.

2.3. Давхар даатгалын компани нь Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн А маягт”-аар жилийн санхүүгийн тайланг_ “Санхүүгийн тайлангийн Б маягт”-аар улирал тутмын санхүүгийн тайланг ирүүлэхээс гадна дараах мэдээллийг энэ журмын 1.2-т заасан хугацаанд гаргаж Хороонд ирүүлнэ:

- 2.3.1. Орлого, зарлагын талаарх мэдээллийг энэ журмын 15 дугаар хавсралтаар;
- 2.3.2. Үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг энэ журмын 26 дугаар хавсралтаар;
- 2.3.3. Орлогын дэлгэрэнгүй мэдээллийг энэ журмын 27 дугаар хавсралтаар;
- 2.3.4. Даатгалын компанийн салбарын ерөнхий мэдээллийг энэ журмын 12 дугаар хавсралтаар;
- 2.3.5. Даатгалын компанийн нэгдлийн талаарх мэдээллийг 13 дугаар хавсралтаар;
- 2.3.6. Холбоотой этгээдүүдтэй хийсэн гүйлгээний талаарх мэдээллийг 14 дүгээр хавсралтаар;
- 2.3.7. Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн талаарх мэдээллийг 15 дугаар хавсралтаар.

2.4. Даатгалын зуучлагч компани нь Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн А маягт”-аар жилийн санхүүгийн тайланг_ “Санхүүгийн тайлангийн Б маягт”-аар улирал тутмын санхүүгийн тайланг ирүүлэхээс гадна дараах мэдээллийг энэ журмын 1.2-т заасан хугацаанд гаргаж Хороонд ирүүлнэ:

- 2.4.1. Орлогын дэлгэрэнгүй мэдээллийг энэ журмын 22 дугаар хавсралтаар;
- 2.4.2. Салбарын дэлгэрэнгүй мэдээллийг 23 дугаар хавсралтаар;
- 2.4.3. Зуучилсан даатгалын үнэлгээ, зуучилсан даатгалын хураамж, зуучлалын орлогын талаарх мэдээллийг энэ журмын 24 дүгээр хавсралтаар.

2.5. Даатгалын хохирол үнэлэгч компани нь Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн А маягт”-аар жилийн санхүүгийн тайланг_ “Санхүүгийн тайлангийн Б маягт”-аар улирал тутмын санхүүгийн тайланг ирүүлэхээс гадна дараах мэдээллийг энэ журмын 1.2-т заасан хугацаанд гаргаж Хороонд ирүүлнэ:

- 2.5.1. Орлогын дэлгэрэнгүй мэдээллийг энэ журмын 19 дүгээр хавсралтаар;
- 2.5.2. Салбарын дэлгэрэнгүй мэдээллийг энэ журмын 20 дугаар хавсралтаар;
- 2.5.3. Даатгалын хохирол үнэлэгчийн даатгалын зүйлийн мэдээллийг 21 дүгээр хавсралтаар.

2.6. Даатгалын компанийн салбар нь дараах мэдээллийг Хороонд ирүүлнэ:

- 2.6.1. “Хөрөнгө, өр төлбөр, орлого, нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг 28 дугаар хавсралтаар”;

2.6.2. “Орлого, нөхөн төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг 29 дүгээр хавсралтаар;

2.7. Энэ журмын 2.6-д заасан хавсралтуудыг харъяалагдах аймаг, нийслэл, дүүрэг, орон нутгийн төлөөлөгчид хүргүүлнэ. Хорооны орон нутгийн төлөөлөгч нь тухайн орон нутаг дахь даатгалын байгууллагын салбарын тайланг нэгтгэж, зайны хяналтын тайланг хагас жилээр гаргаж, жил бүрийн 3 дугаар сарын 1, 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор тус тус Хорооны Даатгалын зохицуулалтын газарт ирүүлнэ.

2.8. Даатгалын байгууллага нь даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, даатгуулагчийн тоо, даатгалын гэрээний тоотой холбогдсон мэдээллийг сар бүрийн 10-ны өдрийн дотор энэ журмын 18 дугаар хавсралтаар гарган Хороонд ирүүлнэ.

2.9. Даатгалын байгууллагын салбар нь салбарын санхүүгийн тайланг гаргаж, энэ журмын 1.2-д заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооны аймаг, нийслэл, дүүрэг дэх орон нутгийн төлөөлөгчид хүргүүлнэ.

ГУРАВ.Хяналт, хариуцлага

3.1. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд журмыг зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.2. Хороо даатгалын байгууллагаас энэ журмын хавсралтын дагуу санхүүгийн нэмэлт тайланг сар бүр гаргаж өгөхийг шаардаж болно.

3.3. Даатгалын компаниас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн зайлшгүй нэмэлт мэдээлэл шаардлагатай болбол Хороо хэзээ ч шаардаж болно.

ДААТГАЛЫН КОМПАНИЙН ДҮРМИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН БАЙРШИЛ

Даатгагчийн нэр.....

20...оны ...сарын ...-ны өдөр

А	Б	В	Д	Е	Ё	Ж	З
Үзүүлэлт	Мөрийн дугаар	Дансны дугаар	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	Хөрөнгө оруулалт	Дүн*	Эзлэх хувь	
1	Бэлэн мөнгө	1					
2	Банкны харилцах (мөр2=мөр3+мөр4+мөр5)	2					
банк (дансны дугаар, дансны төрөл)	3					
банк (дансны дугаар, дансны төрөл)	4					
банк (дансны дугаар, дансны төрөл, монгол банкны ханш***)	5					
3	Банкны хадгаламж (мөр6=мөр7+мөр8+мөр9)	6					
банк (дансны дугаар, дансны төрөл)	7					
банк (дансны дугаар, дансны төрөл)	8					
банк (дансны дугаар, дансны төрөл, монгол банкны ханш***)	9					
4	Банкны хадгаламжийн сертификат (мөр10=мөр11+мөр12+мөр13)	10					
банк (дансны дугаар, дансны төрөл)	11					
банк (дансны дугаар, дансны төрөл)	12					
банк (дансны дугаар, дансны төрөл, монгол банкны ханш***)	13					
5	Үнэт цаас (мөр14=мөр15+мөр16+мөр17+мөр18+мөр19+мөр20+мөр21+мөр22)	14					
	Засгийн газрын өрийн хэрэгсэл	15					
	Төв банкны үнэт цаас	16					
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	17					
	Аймаг, нийслэлийн гаргасан өрийн бичиг	18					
	Компанийн бонд	19					
	ХБ-ийн I ангиллын хувьцаа	20					
	ХБ-ийн II ангиллын хувьцаа	21					
	Хөрөнгө оруулалтын сангийн үнэт цаас /нэгж эрх/	22					
	Бусад	23					
6	Санхүүгийн түрээс	24					
7	Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	25					
8	Үнэт металл, Дериватив	26					
9	Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	27					
 санхүүгийн байгууллага	28					
 санхүүгийн байгууллага	29					
 санхүүгийн байгууллага	30					
10	Үндсэн хөрөнгө (мөр26=мөр27+мөр28)	31					
	Үл хөдлөх хөрөнгө	32					
	Бусад үндсэн хөрөнгө	33					
11	Гадаадад байршуулсан хөрөнгө (мөр29=мөр30+мөр31)	34					
	үүнээс:	35					
	36					
12	Бусад хөрөнгө (мөр26=мөр27+мөр28)	37					
	Даатгалын авлага	38					
	Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө	39					
	Даатгалын хөрөнгө	40					
	Биет бус хөрөнгө	41					
	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх	40					
13	НИЙТ ДҮН (мөр32=мөр1+мөр2+мөр6+мөр10+мөр14+мөр23+мөр24+мөр25+мөр26+мөр29)	41					

ТАЙЛАН ГАРГАСАН.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)
тамга, тэмдэг

.....

(овог, нэр)

Тайлан гаргасан хугацаа:

20...оны...сарын... өдөр

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ын 21 дүгээр хавсралт

ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ КОМПАНИЙН ҮНЭЛСЭН ДААТГАЛЫН ЗҮЙЛ

Даатгалын хохирол үнэлэгчийн нэр:

20...оны ... сарын ...-ны өдөр

№	Даатгалын зүйл	Хэмжих нэгж	Мөрийн дугаар	Даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгалын зүйлийн тоо
А	Б	В	Г	Д
1	Хүний амь нас, эрүүл мэнд	хүн	1	
2	Байшин барилга	ш	2	
3	Тоног төхөөрөмж	ш	3	
4	Бараа материал	ш	4	
5	Автотээврийн хэрэгсэл	ш	5	
6	Ачаа	тн	6	
7	Газар тариалан	га	7	
8	Мал, амьтад	толгой	8	
9	Агаарын хөлөг	ш	9	
10	Мөнгөн хөрөнгө	төгрөг	10	
11	Бусад		11	
	ДҮН		12	

ТАЙЛАН ГАРГАСАН.....

(албан тушаал)

.....
(гарын үсэг)

тамга, тэмдэг

.....
(овог, нэр)

Тайлан гаргасан хугацаа:

20...оны...сарын... өдөр

Маягт нөхөх заавар: (Маягтад дурдсан үзүүлэлт тус бүрийг даатгалын хохирол үнэлэгч компанийн үнэлсэн даатгалын зүйл тус бүрээр нөхнө.)

1. "Хүний амь нас, эрүүл мэнд" - Амь нас, эрүүл мэндийн даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан хүний т
2. "Байшин барилга" - Байшин барилгын даатгалын хохирлын үнэлгээ хийсэн тоог хэлнэ.
3. "Тоног төхөөрөмж" - Тоног төхөөрөмжийн даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан тоог хэлнэ.
4. "Бараа материал" - Бараа материалын даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан материалын тоог хэлнэ.
5. "Автотээврийн хэрэгсэл" - Автотээврийн хэрэгсэлийн даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан тоог хэлнэ.
6. "Ачаа" - Ачааны даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан тонн ачааг хэлнэ.
7. "Газар тариалан" - Газар тариалангийн даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан га газрыг хэлнэ.
8. "Мал, амьтад" - Мал, амьтадын даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан толгой малыг хэлнэ.
9. "Агаарын хөлөг" - Агаарын хөлгийн даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан тоог хэлнэ.
10. "Мөнгөн хөрөнгө" - Мөнгөн хөрөнгийн даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан төгрөгийн хэмжээг хэлнэ.
11. "Бусад" - Даатгалын хохирлын үнэлгээ хийсэн даатгагдсан төмөр замын тээврийн хэрэгсэл, усан замын тээврийн

|

гоог хэлнэ.

йэ.

йэ.

хэрэгсэл, хувьцаа гэх мэтийг хэлнэ.

ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН, ХА

Даатгалын зуучлагчийн нэр:

№	Харилцагч даатгалын компани	Мөрийн дугаар	Зуучилсан даатгалын үнэлгээ	Зуучилсан даатгалын хураамжийн орлого	Зуучилса
					Хувь хүн
А	Б	В	Г	Д	Е
1	Даатгалын компани	1			
1.1	"Ард даатгал" ХХК	2			
1.2	"Бодь даатгал" ХХК	3			
1.3	"Ган зам даатгал" ХХК	4			
1.4	"Гэр даатгал" ХХК	5			
1.5	"Мандал генерал даатгал" ХХК	6			
1.6	"Миг даатгал" ХХК	7			
1.7	"Монре даатгал" ХХК	8			
1.8	"Мөнх даатгал" ХХК	9			
1.9	"Монгол даатгал" ХХК	10			
1.10	"Нэйшнл лайф даатгал" ХХК	11			
1.11	"Номин даатгал" ХХК	12			
1.12	"Хаан даатгал" ХХК	13			
1.13	"Практикал даатгал" ХХК	14			
1.14	"Соёмбо даатгал" ХХК	15			
1.15	"Тэнгэр даатгал" ХХК	16			
1.16	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	17			
1.17	"ХААДД" ХК	18			
1.18	19			
1.19	20			
2	Давхар даатгалын компани	21			
2.1	Давхар даатгалын компани-1	22			
2.2	Давхар даатгалын компани-2	23			
2.3	24			
2.4	25			
	Дүн	26	Дүн=Маягт ДЗ-1-ийн БаганаГ Мөр24	Дүн=Маягт ДЗ-1-ийн БаганаД Мөр24	Дүн=Маягт ДЗ-1-ийн БаганаЕ Мөр24

ТАЙЛАН ГАРГАСАН.....

(албан тушаал)

(гарын үсэг)
тамга, тэмдэг

(овог, нэр)

Тайлан гаргасан хугацаа:

20...оны...сарын... өдөр

Маягт нөхөх заавар: (Маягтад дурдсан үзүүлэлт тус бүрийг даатгалын зуучлагч компанийн харилцагч даатг бүрээр нөхнө.)

1. "Зуучилсан даатгалын үнэлгээ" - Маягт ДЗ-1-ийн маягт нөхөх зааврын дагуу
2. "Зуучилсан даатгалын хураамжийн орлого" - Маягт ДЗ-1-ийн маягт нөхөх зааврын дагуу
3. "Зуучилсан даатгалын гэрээний тоо: Хувь хүн" - Маягт ДЗ-1-ийн маягт нөхөх зааврын дагуу

4. "Зуучилсан даатгалын гэрээний тоо: Хуулийн этгээд" - Маягт ДЗ-1-ийн маягт нөхөх зааврын дагуу
5. "хамрагдсан хувь хүний тоо" - Маягт ДЗ-1-ийн маягт нөхөх зааврын дагуу
6. "Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого" - Маягт ДЗ-1-ийн маягт нөхөх зааврын дагуу

ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙ

Даатгалын зуучлагчийн нэр:

№ А	Харилцагч даатгалын компани Б	Мөрийн дугаар В	Даатгалын гэрээний тоо	Даатгалын үнэлгээ
1	Даатгалын компани	1		
1.1	Даатгалын компани-1	2		
1.2	Даатгалын компани-2	3		
1.3	4		
1.4	5		
1.5	6		
1.6	7		
2	Давхар даатгалын зуучлагч компани	8		
2.1	Давхар даатгалын зуучлагч компани-1	9		
2.2	Давхар даатгалын зуучлагч компани-2	10		
2.3	11		
2.4	12		
	Дүн	13		

ТАЙЛАН ГАРГАСАН.....

(албан тушаал)

Тайлан гаргасан хугацаа:

Маягт нөхөх заавар: (Маягтад дурдсан үзүүлэлт тус бүрийг даатгалын зуучлагч компанийн харилцагч даатгалын компани,

1. "Зуучилсан даатгалын үнэлгээ" - Маягт ДЗ-1-ийн маягт нөхөх зааврын дагуу
2. "Зуучилсан даатгалын хураамжийн орлого" - Маягт ДЗ-1-ийн
3. "Зуучилсан даатгалын гэрээний тоо: Хувь хүн" - Маягт ДЗ-1-
4. "Зуучилсан даатгалын гэрээний тоо: Хуулийн этгээд" - Маягт
5. "хамрагдсан хувь хүний тоо" - Маягт ДЗ-1-ийн маягт нөхөх заавар
6. "Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого" - Маягт ДЗ-1-ийн

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн
санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг
тогтоох журам”-ын 36 дугаар хавсралт

**МАЯГТ - Д5-В. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ГЭРЭЭНИЙ НӨӨЦ САНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Даатгагчийн нэр: _____

20... оны ... сарын ... өдөр

Тайлант хугацаа: _____

(төгрөгөөр)

Даатгалын хэлбэр	Мөрийн дугаар	Эхний үлдэгдэл	нэмэгдсэн	хасагдсан	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2	3	бага 4=бага (1+2-3)
2.1. Хугацаат амьдралын даатгал	1				
2.2. Насан туршийн даатгал	2				
2.3. Хуримтлалын даатгал	3				
2.4. Тэтгэврийн даатгал	4				
2.5. Эрүүл мэндийн даатгал	5				
2.6. Аннуити даатгал	6				
ДҮН	7	ДҮН = Маягт 5-ын бага 1 мөр 3	ДҮН = Маягт 5-ын бага 2 мөр 3	ДҮН = Маягт 5-ын бага 3 мөр 3	ДҮН = Маягт 5-ын бага 4 мөр 3

Жич: Актуар тооцооллыг хавсаргана.

ТАЙЛАН ГАРГАСАН:

(албан тушаал)

(гарын үсэг)

(овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20... оны ... сарын ... өдөр